



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2024 оны 10 сарын 25 өдөр

Дугаар 529

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Зөвшөөрөл олгох тухай" 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эдийн засаг, хөгжлийн яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 23 нэрийн, нийт 9,637,072.00 (есөн сая зургаан зуун гучин долоон мянга далан хоёр) төгрөгийн балансын үнэ, 7,839,367.75 (долоон сая найман зуун гучин есөн мянга гурван зуун жаран долоон төгрөг далан таван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар (Хүний нөөцийн хэлтэс)-т балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Солонгоо, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх, хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Энэхүү тогтоолын хавсралтад заасан, үлдэх өртөггүй хөрөнгийн ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн ирүүлж шийдвэрлүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх системд"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132002424
23-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 18 дугаар сарын 18 өдрийн
329 дугаар тогтоолын хавсралт

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
(ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС)-Т БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Тумбочик-дугуйтай1	10/12/2022	2	128,900.00	257,800.00		257,800.00
2	Шүүгээ7	6/30/2022	1	532,740.00	532,740.00	532,740.00	-
3	Сандал8	6/30/2022	3	149,220.00	447,660.00	447,660.00	-
4	СаНдал	10/12/2022	5	350,000.00	1,750,000.00	612,499.90	1,137,500.10
5	Шүүгээ3	6/30/2022	1	104,710.00	104,710.00	104,710.00	
6	Хивс	6/30/2022	1	741,000.00	741,000.00	741,000.00	
7	Хивс,	6/30/2022	1	598,500.00	598,500.00	598,500.00	
8	Комод	4/14/2022	1	742,900.00	742,900.00	340,495.85	402,404.15
9	Шүүгээ-шилэн номын	6/30/2022	1	731,900.00	731,900.00	731,900.00	
10	Сандал.	6/30/2022	6	607,818.00	3,646,908.00	3,646,908.00	
11	Ширээ-компьютерын	4/14/2022	1	82,954.00	82,954.00	82,954.00	
Дүн			23	4,770,642.00	9,637,072.00	7,839,367.75	1,797,704.25
					(есөн сая зургаан зуун гучин долоон мянга далан хоёр төгрөг)	(долоон сая найман зуун гучин есөн мянга гурван зуун жаран долоон төгрөг далан таван мөнгө)	(нэг сая долоон зуун ерэн долоон мянга долоон зуун дөрвөн төгрөг хорин таван мөнгө)